



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024.05.16

№2024/01

Улаанбаатар хот

Г “Ногдол ашиг хуваарилах тухай”

“Компанийн тухай” хуулийн 46, 47 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн


ТОГТООХ НЬ:

- 1.“Улаанбаатар БҮК”ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас нийт 131 547 500 / нэг зуун гучин нэгэн сая таван зуун дөчин долоон мянга таван зуун / төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.
- 2.Нэгж хувьцаанд 1,0 /нэг / төгрөгийн ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/-д үүрэг болгосугай.
- 3.Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан тарааж эхэлсүгэй.
- 5.Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **Д.НЯМХҮҮ**



“Улаанбаатар БҮК” ХК-ийн
ТУЗ-ийн №.....тоот тогтоолын
хавсралт



“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР
ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийн огноо дугаар	Аль оны ногдол ашиг болох	Нэгж хувьцаанд олгохоор шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашгийн олгож эхлэхээр товлосон хугацаа	Ногдол ашгийг олгох хэлбэр /мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас/	Ногдол ашгийг хаана олгох
2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийнтоот ТУЗ-ийн тогтоол	2023 оны жилийн эцсийн ногдол ашиг	1,0 төгрөг	2024-6-01	Мөнгөн хэлбэрээр	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК